

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх заалт, 4.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Ганцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

Гарын үсэг

МАЛЧНЫ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НЭГ УДАА НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Малчны тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчин, (цаашид “малчин” гэх)-ы тэтгэврийн даатгалын шимтгэл (цаашид “шимтгэл” гэх)-ийг нэг удаа нөхөн төлүүлэх, орлогыг төвлөрүүлэх, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, тайлагнах, шимтгэл нөхөн төлсөн хугацааг хянан баталгаажуулахад энэ журмыг мөрдөнө.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9-д заасан, нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоогүй, 1995-2025 онд малчнаар ажиллаж байсан болон ажиллаж байгаа, 10-с дээш жил шимтгэл төлсөн малчин даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг 5 хүртэл жилээр нэг удаа нөхөн төлүүлнэ.

Гурав. Шимтгэлийн хэмжээ, шимтгэл төлөх

3.1. Малчны нэг сарын нөхөн төлөх шимтгэлийн хэмжээ нь Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооноос баталсан 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 792,000 төгрөгт ногдох тухайн үед мөрдөж байгаа сайн дурын даатгуулагчийн тэтгэврийн даатгалын хувь хэмжээгээр буюу 11.5 хувиар тооцсон дүн байна.

3.2. Малчин энэ журмын 3.1-д заасны дагуу шимтгэлийг нөхөн төлөх сарын тоогоор үржүүлж тооцсон нийт шимтгэлийг нийгмийн даатгалын сангийн холбогдох дансанд нэг удаа бүрэн төлнө.

Дөрөв. Иргэн шимтгэл нөхөн төлөх хугацаагаа тодорхойлох, хүсэлт гаргах, нөхөн төлөх

4.1. Малчин нь шимтгэл нөхөн төлөх хүсэлтээ холбогдох баримт бичгийн хамт өөрийн харьяалагдах үндсэн болон түр оршин суугаа газрын харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар (байцаагч)-т 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл энэ журамд заасны дагуу гаргана.

4.2. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар (байцаагч) нь малчнаар ажилласан жилийг тодорхойлохдоо малчин болон малчин өрхийн мал маллаж буй гишүүнийг мал тооллогын “А” дансанд малчнаар бүртгэгдсэн нэр, регистр (иргэний бүртгэлийн дугаар), малчинтай ямар хамааралтайг нотлох баримт бичиг, малчны мал тооллогын “А” дансны баримтыг шалгаж шимтгэл нөхөн төлүүлж ажиллана.

Малчин гэдгийг нотлох баримт бичиг бүрдээгүй байхад шимтгэл төлсөн хугацааг тухайн даатгуулагчийг малчнаар даатгуулсан хугацаанд тооцохгүй. Уг төлсөн шимтгэлийг бүртгэхгүйгээр иргэнд буцаан олгоно.

4.3. Малчны шимтгэл нөхөн төлөх хугацааг өөрийн санхүүгийн боломж, энэ журмын 4.2-т заасантай нийцүүлэн дараах байдлаар сонгож болно:

4.3.1. энэ журмын 2.1-д заасан хугацаанд мал маллаж, малчнаар ажиллаж байсан А данстай шимтгэл төлөөгүй өөрийн хүсэлтээр сонгосон 5 хүртэлх жилүүд;

4.3.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтад заасан шимтгэл төлсөн байвал зохих хугацааг хангахад шаардагдах 5 хүртэлх жилүүд.

4.4. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар (байцаагч) нь энэ журмын 4.3-т заасан нөхөн төлөх хугацааг сонгоход иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

4.5. Малчны ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, коллежид болон бусад сургуульд суралцсан, малчнаас өөр ажил хөдөлмөр эрхэлсэн, цэргийн алба хаасан, хорих ял биеэр эдэлсэн, гадаад оронд амьдарсан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

4.6. Малын “А” данс нь “Мал бүхий өрх”-өөр бүртгэгдсэн бол тухайн “А” дансны эзэмшигчийг малчин гэж үзнэ. Харин мал бүхий өрхийн бусад гишүүнийг малчинд хамааруулахгүй. Малчин өрхийн малчин гишүүн энэ журмын дагуу шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан тохиолдолд зөвхөн малчин өрхийн “А” дансанд бүртгэгдсэн малчны тоо болон малчны мэдээлэл хэсэгт бүртгэгдсэн овог, нэр, регистрийн дугаарын бүртгэлтэй тулган шалгана.

4.7. Малчны “А” данс үрэгдсэн, архивт байхгүй тохиолдолд Засгийн газрын 2023 оны 450 дугаар тогтоолоор баталсан “Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам”-ын 2.3-т заасан нэмэлт баримт бичгийг бүрдүүлж, түүнийг үндэслэн малчнаар ажилласан гэж үзэж уг хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлнэ. Энэ тохиолдолд тухайн нэмэлт баримт бичгээр малчин өрхийн тэргүүн болон эхнэрийг малчинд хамааруулна.

4.8. Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацааг Хөдөлмөрийн тухай хуулийн 142 дугаар зүйлийн 142.1 дэх хэсэгт заасны дагуу 15 нас хүрсэн өдрөөс эхлэн тооцно.

4.9. Малчны “А” данс бүхий малчнаар ажиллаж байсан шимтгэл төлөөгүй хугацаанд нөхөн төлөхөөр өөрийн сонгосон нийт хугацааны шимтгэлийг холбогдох баримт бичгийг үндэслэн өөрийн харьяалах нийгмийн даатгалын газар (байцаагч)-т шалгуулсны дараа 1 удаа бүрэн төлж, шимтгэл төлсөн баримтыг бусад баримт бичгийн хамт хүлээлгэн өгнө.

Тав. Шимтгэл нөхөн төлөх хугацааг баталгаажуулахад төрийн байгууллагатай хамтран ажиллах

5.1.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь малчны шимтгэл нөхөн төлөх хугацааг бодитой тодорхойлох зорилгоор холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллана.

5.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа байгууллага, боловсролын сургалтын байгууллага нь иргэний шимтгэл нөхөн төлөх онуудад ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, коллежийн ангид суралцсан, эсвэл төгссөн эсэхийг тодорхойлоход шаардагдах мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр солилцож хамтран ажиллана.

5.3.Цагдаагийн ерөнхий газар нь иргэний шимтгэл нөхөн төлөх онуудад хорих ял биеэр эдэлж байсан эсэх мэдээллийг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь иргэний хоригдож байгаа эсэх тухай мэдээллийг цахим болон цаасан хэлбэрээр нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай тус тус солилцож хамтран ажиллана.

Зургаа. Шимтгэл нөхөн төлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэдгээрийг хадгалах

6.1.Малчин нь шимтгэлээ нөхөн төлөхдөө иргэний үнэмлэх, мал, тэжээвэр амьтад, малын хашаа, худгийн тооллогын маягт (цаашид “мал тооллогын “А” данс” гэх)-ыг нийгмийн даатгалын дэвтэр, шаардлагатай тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг харьяа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар (байцаагч)-т ирүүлнэ.

6.2.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар (байцаагч) нь энэ журмын 4.5-д заасны дагуу малчны ажилласан болон шимтгэл төлсөн хугацааг бодитой тогтооход туслах зорилгоор ажилласан хугацааг тогтоосон тухай шүүхийн шийдвэр, хугацаат цэргийн алба хаасан тухай цэргийн үнэмлэх, батлах, лавлагааг шаардлагатай тохиолдолд гаргуулан авч болно.

6.3. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар (байцаагч) нь энэ журмын 6.1, 6.2-т заасан лавлагаа, тодорхойлолтыг иргэний өөрийнх нь зөвшөөрлийн үндсэн дээр “lavлагаа.e-mongolia.mn” цахим системээс бүрдүүлж болно.

6.4.Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар шимтгэл нөхөн төлсөн иргэн бүрийн энэ журмын 5.2-5.3, 6.1-6.2-т заасан баримт бичгийг архивын хадгаламжийн нэгж болгон хадгална.

Долоо. Мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, баталгаажилтын хуудас олгох

7.1.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар нь шимтгэлийг тэтгэврийн даатгалын санд бүрэн нөхөн төлсөн малчны оршин сууж байгаа аймаг (сум), дүүрэг (хороо)-ээр нь мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, тайланг сар бүр гаргаж, дараа сарын 5-ны өдрийн дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

7.2.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 7.1-д заасан тайланг хянан шалгасны үндсэн дээр энэ журмын хавсралтаар баталсан “Баталгаажилтын хуудас” (шимтгэлийг нөхөн тооцсон тухай тэмдэглэлийн хамт)-ыг (цаашид “Баталгаажилтын хуудас” гэх) албажуулан сар бүрийн 30-ны өдрийн дотор холбогдох аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт хүргүүлнэ.

7.3.Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 7.1, 7.2-т заасан тайлан, мэдээг улирал бүр гаргаж, улирлын дараа сарын 15-ны өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.4.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар нь энэ журмын 7.2-т заасны дагуу хүлээн авсан “Баталгаажилтын хуудас”-ыг тамга, тэмдгээр баталгаажуулж, малчинд олгоно.

7.5.“Баталгаажилтын хуудас” нь нийгмийн даатгалын дэвтрийн нэгэн адил хүчин төгөлдөр баримт бичиг байна.

7.6.Малчин нь “Баталгаажилтын хуудас”-аа үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох нийгмийн даатгалын газар түүний хувийн хэрэг болон нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд үндэслэн лавлагаа авч болно.

7.7. “Баталгаажилтын хуудас”-ыг хуурамчаар үйлдэхийг хориглоно.

Найм. Шимтгэл нөхөн төлсөн хугацааг тэтгэвэр тогтооход баримтлах

8.1.Шимтгэл нөхөн төлсөн малчин Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан тэтгэвэр тогтоолгох нөхцөл, болзлыг хангаж шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан бол түүний шимтгэл нөхөн төлсөн хугацааг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шимтгэл төлсөн нийт хугацаанд оруулан тооцно.

8.2.Шимтгэл нөхөн төлсөн хугацаа нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 5.1.7 дахь хэсэгт заасан хугацаа болон цэргийн алба хаасан хугацаанд хамаарахгүй.

Ес. Бусад

9.1.Малчны шимтгэл нөхөн төлүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар эрхлэн гүйцэтгэж, нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана.

9.2.Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Засгийн газрын 2025 оны дугаар сарын-ны
 өдрийн.... дугаар тогтоолын хавсралтаар баталсан
 “Малчин тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг
 удаа нөхөн төлүүлэх журам”-ын хавсралт

БАТАЛГААЖИЛТЫН ХУУДАС №.....

Иргэновгийн.....(эцэг/эхийн)-ийн..... (нэр)
 (РД.....) нь Малчны тухай хуульд заасны дагуу 1995 оноос хойш малчнаар
 нийтдээ жил сар тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн болохыг баталгаажуулав.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга...../ /
 Нийгмийн даатгалын улсын ерөнхий байцаагч...../ /

2025 оны ... дугаар сарын -ны өдөр

.....тоот “Баталгаажилтын хуудас”-тай
овгийн.....(эцэг/эхийн)-ийн..... (нэр)
 (РД.....)-ний
 тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлсөн тухай тэмдэглэл

Он	Сарууд												Нийт сарын тоо
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1995													
1996													
1997													
1998													
1999													
2000													
2001													
2002													
2003													
2004													
2005													
2006													

2007														
2008														
2009														
2010														
2011														
2012														
2013														
2014														
2015														
2016														
2017														
2018														
2019														
2020														
2021														
2022														
2023														
2024														
2025														
Нийт жил, сар	(.....жил.....сар, санд төлсөн шимтгэл.....төгрөг)													

Тайлбар: Малчнаар ажиллаж, шимтгэл төлсөн хугацааг “М” үсгээр тэмдэглэнэ.

Хянаж баталгаажуулсан:

.....аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга...../ /
 Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга...../ /